



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/67

Сангиндалай

Үнэлгээний хороо байгуулах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хийгдэх “Эрдэнэдалай сумын Хүүхдийн ордны тохижилт” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Нямаа (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Өнөрбилэг (Олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан)

Гишүүдэд: Э.Бат-Амьдрал (7-р багийн иргэн)  
Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)  
Т.Энхбат (Тусгай сан хариуцсан нягтлан бодогч)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж архивд хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



482302133